



Кооэй Судалгааны Хүрээлэн

## ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2011 оны 3-р сар №1

**“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” хэрэгжиж байна.**

### Төслийн тойм

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлж эхлэсэн билээ. Энэхүү шинэ стандартыг сургуулийн сургалтанд бодитоор хэрэгжүүлэхэд багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших шаардлага гарсан юм.

Иймд Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ) энэхүү шаардлагыг хангах зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагатай (JICA) хамтран 2010 оны 4 дүгээр сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл (хоёр дахь шат)”-ийг хэрэгжүүлж эхлэсэн. Энэхүү төсөл нь 2006-2009 онуудад хэрэгжсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (нэгдүгээр шат)” төслийн үргэлжлэл юм.

2010 оны 4 дүгээр сараас 2013 оны 3 дугаар сар хүртэл хэрэгжүүлэх уг төслийн зорилго нь нэгдүгээр шатны төслийн хүрээнд 8 судлагдахууны жишээн дээр боловсруулсан арга зүйн зөвлөмж, хоёр дахь шатны төслийн зөвлөмж боловсруулж буй сургалтын модуль зэрэгт тулгуурлан, загвар аймаг дүүргийн загвар сургуулиудад зохион байгуулах сургалтаар дамжуулан суралцахуйд суурилсан шинэ арга зүйг суурь боловсролын шинэ стандартад нийцүүлэн үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц тогтолцоог буй болгон бэхжүүлэх явдал юм.

Тус төслийн хүрээнд Боловсролын хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн “Байгалийн ухааны боловсролын сорил-туршлага хөгжлийн төв”, Боловсролын Их Сургуулийн “Бага боловсролын дидактик сургалт судалгааны төв”, “Математик боловсролын туршилт судалгааны төв”, “Мэдээлэл зүйн боловсролын арга зүйн төв”, нэгдүгээр шатны төслийн загвар сургуулиудын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн багийг байгуулсан. Энэхүү мэргэжлийн баг нь сургалтын модуль боловсруулан, аймаг дүүргийн түвшинд хичээлийн судалгаа хийх загварыг буй болгох, түүнийг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Энэ удаагийн төслийн хүрээнд дараахи үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд;

- Боловсрол соёлын газрын (БСГ) дарга мэргэжилтэн, Ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) удирдлага, багш нарт зориулсан багшлахуйн арга зүйг сайжруулахад чиглэсэн сургалтын модулийг боловсруулах, засаж сайжруулах.

- Загвар аймаг дүүргийн загвар сургуулиудад сургалтын модулийг турших. (Сургалт зохион байгуулах)
- Загвар аймаг дүүргийн загвар сургуулиудад “Хичээлийн судалгаа” хэрэгжүүлж, аймаг дүүргийн болон ЕБС-ийн түвшинд багш нар арга зүйгээ сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.
- Бүх аймаг дүүргийн БСГ-ын дарга мэргэжилтэн болон загвар сургуулиудын удирдлага, багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулах.

### Төслийн онцлог:

- Хүүхдийн суралцахуйг дэмжсэн багшийн арга зүйг хөгжүүлэхэд чиглэсэн.
- Материаллаг бус, оюуны хөрөнгө оруулалтын хэлбэртэй.
- Ерөнхий боловсрол, дээд боловсролын залгамж холбоо, хамтын ажиллагааны бодит байдлыг ажил хэрэгчээр хангаж байна.

### Нэгдүгээр шатны төслийн талаар

“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (нэгдүгээр шат)” төслийг суурь боловсролын шинэ стандартад нийцсэн хүүхдийн хөгжлийг дэмжих шинэ арга зүй боловсруулах зорилгоор 2006 оны 4 дүгээр сараас 2009 оны 8 дугаар сар хүртэл БСШУЯ, JICA-тай хамтран амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд загвар сургуулиудын туршилт хичээлээр дамжуулан 8 судлагдахуун (Физик, Хими, Хүн-Орчин, Хүн-Байгаль, Бага ангийн математик, Дунд ангийн математик, Мэдээлэл зүй, Төсөлт ажил) тус бүрээр багш нарт зориулсан арга зүйн гурван цуврал зөвлөмж, “Хичээлд мониторинг хийх зөвлөмж”, “Зөвлөмж боловсруулах гарын авлага”-ыг боловсруулсан.

Уг төсөлд Нийслэлийн Боловсролын Газар, 45-р сургууль, 97-р сургууль, “Сэтгэмж” цогцолбор сургууль, Дорнод аймгийн 5-р сургууль, “Хан-Уул” цогцолбор сургууль, Матад сумын сургууль, Сэлэнгэ аймгийн 1-р сургууль, 4-р сургууль, Хушаат сумын сургуулиуд загвар сургуулиар оролцсон бөгөөд эдгээр сургуулиудын төлөөлөл эдүгээ мэргэжлийн багийн бүрэлдэхүүнд багтан хоёр дахь шатны төсөлд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

### Багшлахуйн арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх арга зам



### Гарчиг:

Төслийн тойм	1
Өмнөх төслийн талаар товчхон	1
Хичээлийн судалгаа	2
Загвар аймаг дүүрэг, загвар сургуулиуд	2
Цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай товч	2
Төсөлд оролцогчдын сэтгэгдэл	2-3
Сургалтын модуль танилцуулга	3
Сургалтын танилцуулга	4
Суралцах чадварын үнэлгээний дүн	4
Төслийн багийн танилцуулга	4

**Хичээлийн судалгаа**

Багш нар арга зүйгээ бусад багш нарт үзүүлэн, тэдний зөвлөгөөг авах замаар өөрийн арга зүйгээ улам сайжруулахын хамт сайжруулсан арга зүйгээ бусад багш нарт түгээн дэлгэрүүлэх юм. Хөтөлбөр боловсруулан хичээл заах, хичээлд ажиглалт, хэлэлцүүлэг хийх зэрэг нь хичээлийн судалгаанд хамаарна. Хичээлийн судалгааг Японд 100 гаруй жилийн өмнөөс хийж эхэлсэн ба эдүгээ дэлхий нийтийн боловсролын салбарын анхаарлыг зүй ёсоор татах болсон байна.

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам “2010-2011 оны хичээлийн жилийн зорилт” баримт бичигтээ хичээлийн судалгааны тухай тодорхой тусгасан бөгөөд энэхүү зорилтоор дамжуулан орон даяар багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд тус дэм болгох чиглэлээ тодорхойлсон.

**Загвар аймаг дүүрэг, загвар сургуулиуд**

Энэ удаагийн төслийн загвар аймаг дүүргээр Сонгинохайрхан дүүрэг (СХД), Булган, Завхан аймгууд сонгогдсон. Загвар сургуулиар СХД-ийн “Ирээдүй” цогцолбор сургууль, 12-р сургууль, 67-р сургууль, Булган аймгийн 1-р сургууль, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Гурванбулаг сумын сургууль, Завхан аймгийн “Чандмань Эрдэнэ” цогцолбор сургууль, Тосонцэнгэл, Сонгино, Баянтэс, Завханмандал, Шилүүстэй сумын сургуулиуд (нийт 14 сургууль) сонгогдсон бөгөөд төслийг хэрэгжүүлэх гурван жилийн хугацаанд эдгээр загвар аймаг дүүргийн загвар сургуулиудад түшиглэн багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэн, бусад аймаг дүүрэгт түгээн дэлгэрүүлэх эхлэлийг тавих юм.

**2011-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай**

- 2011 оны 2-3 дугаар сард мэргэжлийн баг болон төслийн баг бүх загвар сургуулийн хичээлийн судалгаанд мониторинг хийхээр төлөвлөж байна.
- 2011 оны 11 дүгээр сар, 2012 оны 11 дүгээр сард Улаанбаатар хот болон Булган, Завхан, Дорнод, Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн төлөөлөлд зориулсан сургалтыг тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн.

**Төсөлд оролцогчдын сэтгэгдэл****Ц.Наранцэцэг, МУБИС-ийн ББДССТ-ийн эрхлэгч (Төсөлт ажлын зөвлөмж боловсруулах багийн ахлагч)**

Нэгдүгээр шатны төсөл нь өмнө нь хэрэгжсэн бусад ямар ч төслөөс илүүтэй багш нарын анхаарлыг татсан гэж бодож байна. Багш нар хамтран хичээлд бэлтгэж, зааж, ажиглалт хийн, үр дүнг хэлэлцэж байснаараа харилцан бие биенээсээ ихийг суралцсан гэдгийг онцлон тэмдэглүүштэй.

Төсөлт ажлын зөвлөмж II, III нь төсөлт ажил хичээлийн бодит жишээтэй танилцахыг хүссэн багш нарын эрэлт хэрэгцээнд яв цав нийцсэн зүйл болсон. Үр дүнд нь багш нар төсөлт ажил хичээлийг тодорхой бус ойлгомжгүй байдлаар явуулах биш, зөвлөмжид тулгуурлан жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж сурсан.

Сурагчдын сурах хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлэн, бие даасан бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлсэн. Төсөлт ажил нь хүүхдүүдийн идэвхийг өрнүүлээд зогсохгүй, бусад хичээлд нь ч эерэг нөлөө үзүүлсэн хэмээн багш нар ярьж байна.

Гурван зөвлөмжийг цогц байдлаар агуулгын хувьд уялдаа холбоотой бичсэн тул өнгөц унших бус нэгд нэггүй уншиж судлах нь зүйтэй.

**М.Ганбат, МУИС-ийн Физик электроникийн сургуулийн Физик боловсролын тэнхимийн эрхлэгч (Физикийн зөвлөмж боловсруулах багийн ахлагч)**

Өмнөх төслийн эхний үед юу хийх ёстой нь ойлгомжгүй байсан ч явцын дүнд зөвлөмж боловсруулах ажилд тодорхой сэдэв дээр тодорхой үүрэгтэйгээр оролцох болсон. Үүний дүнд 7, 8, 9-р ангид заадаг “Цахилгаан гүйдэл” бүлэг сэдвээр зөвлөмж боловсруулсан ба зөвлөмжид физикийн арга зүйн онцлог, нэгж болон ээлжит хичээлийн судалгаа хийх үе шат, алхмуудаас гадна хичээлийн киррикулум боловсруулснаараа онцлогтой. Энэ нь багш нарын хичээлийн хөтөлбөр боловсруулахад тус нэмэр болсон болов уу. Зөвлөмжийг туршиж үзсэн багш нар сурсан зүйлээ хичээлдээ байнга ашиглан, өөрсдийгөө хөгжүүлэхээр хичээн ажиллаж байна. Түүнчлэн бусад багш нар ч мөн ийм хандлагатай болсон.

Энэхүү төслөөр хэрэгжүүлдэг хичээлийн судалгаа нь, багшийн арга зүйд үнэлгээ өгч, ерөнхийд нь сайн муу хичээл боллоо гэж үнэлээд өнгөрдөг арга зүйгээс зарчмын хувьд ялгаатай юм. Багш нар хамтран хичээлийг олон талаас нь судлах бөгөөд тэрхүү судалгаандаа үндэслэн хичээлд бэлтгэж,

харилцан суралцах явдалд гол анхаарлаа хандуулах нь чухал.

Манай орны боловсролын байгууллагуудын шат шатны төлөөлөл төслийн хоёр дахь шатанд идэвхитэй оролцож байгаа нь туйлын чухал. Төслийн эхний шатанд өөр мэргэжлийн хүмүүс хамтарч нэг асуудлыг шийдвэрлэж байсан нь урьд байгаагүй ололт байлаа. Харин багаар ажиллах тал дээр бид улам ихийг сурах шаардлагатай байна. Учир нь төслийн эхний шатаар дамжуулан багш, мэргэжилтнүүд гайхалтай өссөн нь хамтын ажиллагааны үр дүн гэж хэлж болно.

**Ц.Намжилдорж, Нийслэлийн 45-р сургуулийн захирал (Нэгдүгээр шатны төсөлд загвар сургуулиар оролцон хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга зүйд суралцаж, түршилт хичээлүүд зохион байгуулсан)**

Төслийн эхний шат сургуулийн түвшинд амжилттай хэрэгжсэн нь боловсролын бүх шатны байгууллагын хамтын ажиллагааны үр дүн юм. Их дээд сургуулийн багш нарын онолын мэдлэг, дунд сургуулийн багш нарын хүүхэдтэй ажиллах туршлагаа харилцан солилцож бие биенээсээ суралцсан. Зөвлөмж нь төсөлд оролцсон бүх хүмүүсийн оюуны бүтээл болж чадсан.

Өмнөх төслийн эхний үед мэдлэг дамжуулах хуучин арга зүйгээс сурагчдаар мэдлэг бүтээлгэх шинэ арга зүйд суралцах явцад зөрчил үүсч, хичээлийн бэлтгэлд маш их цаг зарцуулж байлаа. Хичээлийн хэлэлцүүлгийн үед багшийг шүүмжлэх сэтгэлгээ давамгайлж байсан ч, яваандаа өөрчлөгдөн бие биенээ дэмжиж тусалдаг болсон. Багш нар сурагчдыг сэдэлжүүлэх, мэдлэг бүтээлгэх, идэвхийг өрнүүлэх, чадвар эзэмшүүлэх тал дээр түлхүү анхаарах болсон. Хичээлийн агуулгыг амьдралтай холбон, уламжлалт аргыг шинэ аргатай хослуулан заадаг болсон.

Цаашид арга зүйн шинэчлэлийг улам бүр түгээн дэлгэрүүлэхийн тулд зөвлөмжүүдийг сайтар уншиж судлах шаардлагатай юм. Удирдлага, багш нар сургалтын шинэ арга зүй болон хичээлийн судалгааны талаархи нэгдсэн зөвлөмж гаргаж, багш нар тэрхүү зөвлөмжийн дагуу хичээлээ зааж, хичээлийн судалгаа хийх хэрэгтэй. Мөн, сургууль бүрийн онцлогт тохируулан менежмент боловсруулах хэрэгтэй.

(Үргэлжлэлийг хуудас 3-аас үзнэ үү)

## Төсөлд оролцогчидтой хийсэн ярилцлага (үргэлжлэл)

### Ё.Алтангэрэл, Дорнод аймгийн “Хан-Уул” цогцолбор сургуулийн сургалтын менежер (Нэгдүгээр шатны төслийн загвар сургуулийн төлөөлөл)

Нэгдүгээр шатны төслийн давуу тал нь онолын өндөр мэдлэгтэй их дээд сургуулийн багш нар болон хүүхэдтэй ажиллах баялаг туршлагатай дунд сургуулийн багш нарын харилцан уялдаатай хамтын ажиллагаа байсан. Хичээлийн судалгааг хэрхэн хийх, хичээлийн хэрэглэгдэхүүн болон сургалтын материалыг хэрхэн бэлтгэх, багаар ажиллахын чухлыг ойлгосон.

Эхний үед сурагчдаар мэдлэг бүтээлгэх явцад их цаг зарцуулж байсан ч аажимдаа энэ бэрхшээл үгүй болсон. Багш нар хичээлийн хэрэглэгдэхүүнийг зөв оновчтой тооцох, амьдралд суурилсан мэдлэг бүтээлгэхэд голлон анхаарах болсон. Мөн, гарын доорхи материал ашиглан хэрэглэгдэхүүнээ бэлтгэх болсон. Сурагчид хичээлд идэвхитэй оролцох болсон зэргээр хичээлд хандах хандлага ч өөрчлөгдсөн.

Төслийн хоёр дахь шатанд өнөөг хүртэл төсөлд хамрагдаагүй багш, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт явуулж, зөвлөмжийг бүх багш нарт гарын авлага болгон ашиглуулж сургах шаардлагатай байна. Мөн, багш нар судлагдахуун тус бүрээр баг бүрдүүлэн, хамтарч хичээлийн судалгаагаа хийх нь чухал юм.

### Л.Сувдаа, Сэлэнгэ аймгийн БСГ-ын ахлах мэргэжилтэн (Сэлэнгэ аймгийн загвар гурван сургуульд түршилт хичээл явуулахад дэмжлэг үзүүлдэг)

Төслийн нэгдүгээр шатанд Сэлэнгэ аймгийн загвар гурван сургууль дээр туршилт хичээл хийх бэлтгэл ажлыг хангаж, хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар хичээлийн хөтөлбөрийг сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Арга зүйн шинэчлэлд ихээхэн цаг хугацаа шаардагдах бөгөөд хичээлийн зарим хэрэглэгдэхүүн дутагдах бэрхшээл гарч байсан.

Харин төсөл хэрэгжих хугацаанд асуудлыг томъёолох, шийдвэрлэх, таамаглал дэвшүүлэх, турших, ажиглах, хэлэлцүүлэг хийх зэрэгт суралцсан.

Мэдээлэл дамжуулах сургалтаас мэдлэг бүтээлгэх сургалтын арга зүйд шилжин, сурагчид хамтарч асуудлаа шийдэх болсноор сурагчдын сурах идэвхи, хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлж чадсан. Загвар бус сургуулиудын 280 багшид арга зүйн шинэчлэлийн сургалт явуулсан нь үр дүнтэй болсон.

Багш нарын ажилдаа хандах хандлага сэтгэлгээг өөрчлөх нь арга зүйн шинэчлэл дэх тулгамдсан асуудал юм. Багш нар хичээлийн бэлтгэлд илүү их цаг зав гарган, хичээлд тогтмол ажиглалт, хэлэлцүүлэг хийх замаар хичээлийн хөтөлбөрөө сайжруулахын тулд хичээлийн судалгааг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.

Энэхүү төсөлд боловсролын олон байгууллагын төлөөлөл орж ажилласан нь бие биенээсээ суралцах өргөн боломжийг нээж өгсөн. Төсөлд оролцогчид энэхүү хамтын ажиллагаандаа сэтгэл өндөр байсан.

### Сонгинохайрхан дүүрэг дэх сургалт



Ерөнхий хэсгийн лекц



Төсөлт ажлын багийн сургалт



Нэгдүгээр шатны төсөлд оролцсон загвар сургуулийн “Туршлага сургамж” лекц

## Сургалтын модулийн танилцуулга

Тус төслийн хүрээнд боловсруулж буй сургалтын модулийн талаар танилцуулъя. Сургалтын модулийг дараахи гурван зорилгоор боловсруулж байна.

1. Сургалтанд оролцогчдын боловсролын стандартад суурилсан багшийн арга зүйн шинэчлэл, хичээлийн судалгааны арга зүйн талаархи ойлголтыг гүнзгийрүүлэх.
2. Сургалтанд оролцогчдод арга зүйн шинэчлэл дэх үүрэг оролцооных нь талаар ойлголт өгч, бодитоор хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэх.
3. Сургалтанд оролцогчид бүх аймаг дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийн тогтолцоог бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах.

Багшлахуйн арга зүйг шинэчлэхдээ, зөвхөн багш нарын ойлголтыг гүнзгийрүүлэн арга барилыг нь дээшлүүлээд зогсохгүй, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг чиглэл үзүүлж ажиллах үүрэгтэй Боловсрол соёлын газрын дарга мэргэжилтэн, сургуулийн удирдлага ч арга зүйн шинэчлэлийн талаархи ойлголтдоо гүнзгийрүүлэн бүгд хамтран ажиллах явдал зайлшгүй чухал юм. Иймд энэхүү сургалтын модуль нь багшийн модуль (Боловсрол соёлын газрын мэргэжилтэн, багш нарт зориулсан) болон удирдлагын модулиас (Боловсрол соёлын газрын дарга, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, сургуулийн удирдлагад зориулсан) бүрдэнэ.

Энэхүү модульд боловсролын стандарт болон шавь төвтэй сургалтын арга зүйн үзэл баримтлал, судлагдахуун бүрт (Физик, хими, хүн-орчин, хүн-байгаль, бага ангийн математик, дунд ангийн математик, мэдээлэл зүй төсөлт ажил) мэдлэг бүтээлгэх шинэ арга зүйг нэвтрүүлэх аргачлал, “Хичээлийн судалгаа”-г хэрэгжүүлэх арга зүй зэргийг багтаасан. 2010 оны 11 дүгээр сард уг модулийг ашиглан загвар аймаг дүүргийн (СХД, Булган аймаг, Завхан аймаг) БСГ болон загвар сургуулиудад зориулсан сургалт (дор дурьдах) зохион байгуулсан. Энэхүү сургалтад хамрагдсан загвар аймаг дүүрэг, загвар сургуулиудын хичээлийн судалгаа хийж буй байдалд хийсэн мониторингийн дүнг үндэслэн, энэхүү сургалтын модулийг улам сайжруулахаар төлөвлөж байна.

### Булган аймаг дахь сургалт



Дунд ангийн математикийн баг



Бага ангийн математикийн хичээлд ажиглалт хийж байна



Хүн орчин хичээлийн хэлэлцүүлэг

**Завхан аймаг дахь сургалт**



Эхний өдрийн нэгдсэн лекц



Химийн туршилт хичээл



Физикийн хичээлийн туршилт

**Төслийн багийн танилцуулга:**



JICA-гийн төслийн багт дор нэр дурьдах хүмүүсээс гадна орчуулагч Г.Норжмаа, Х.Ганбаатар, жолооч Р.Баттогтох нар ажиллаж байна.

**Хаяг:**

БСШУЯ, Засгийн газрын 3-р байр, 119 тоот  
Бага тойруу-44, Улаанбаатар, Монгол Улс  
Утас/Факс: 976-1 1-322552, 98900323  
Мэйл хаяг: jicactm@gmail.com

**Сургалтын танилцуулга**

Төслийн баг 2010 оны 11 дүгээр сард загвар аймаг дүүргийн БСГ-ууд болон загвар сургуулиудын төлөөлөлд зориулсан сургалтыг зохион байгууллаа. (СХД: 11 дүгээр сарын 1-5, Булган аймаг: 11 дүгээр сарын 12-16, Завхан аймаг : 11 дүгээр сарын 19-23)

Энэхүү сургалт нь багш удирдлага мэргэжилтнүүдийн суралцахуйд суурилсан арга зүйг сайжруулах болон хичээлийн судалгааны талаархи мэдлэгийг нь гүнзгийрүүлэн, багшлахуйн арга зүйн шинэчлэл дэх багш удирдагч, мэргэжилтнүүдийн үүрэг оролцооны тухай ойлголт өгч, багш нарт хичээлийн судалгааг зохион байгуулах чадварыг олгох зорилготой юм.

Оролцогчидын боловсролын стандарт болон цогц чадамжийн талаархи ойлголтыг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ суралцахуйд суурилсан шинэ арга зүйн тухай нэгдмэл ойлголттой болгох зорилгоор сургалтын эхний өдөр нэгдсэн журмаар лекц зохион байгуулсан. Хоёр буюу гурав дахь өдөр хичээл бүрийн сургалтын шинэ арга зүй, түүнчлэн арга зүйг сайжруулах арга зам болох “Хичээлийн судалгаа”-ны тухай танилцуулсан. Дөрөв дэх өдөр туршилтын хичээл заан, ажиглалт хэлэлцүүлэг зохион байгуулан оролцогчид өөрсдөө оролцон “Хичээлийн судалгаа”-ны тухай ойлголттоо гүнзгийрүүлсэн. Харин тав дахь өдөр нь арга зүйгээ цаашид хэрхэн сайжруулах вэ гэсэн асуудлаар байгууллага сургууль бүр үйл ажиллагааныхаа график төлөвлөгөөг боловсруулан түүнийгээ танилцуулсан.

		Багшийн модуль	Удирдлагын модуль
Зорилтот бүлэг		<ul style="list-style-type: none"> <li>БСГ-ын мэргэжилтэн</li> <li>Багш нар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>БСГ-ын дарга, мэргэжилтэн</li> <li>Сургуулийн захирал</li> <li>Сургалтын менежер</li> </ul>
Судлагдах уун		Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Хими, Физик, Хүн-Байгаль, Хүн-Орчин, Мэдээлэл зүй, Төсөлт ажил	
Модулийн агуулга	1 дэх өдөр	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ арга зүйн тухай</li> <li>Японы хичээлийн судалгааны танилцуулга</li> <li>Хичээлийн судалгааны тухай</li> <li>Нэгдүгээр шатны төслийн туршлагаас танилцуулах</li> </ul>	Нийт оролцогчид нэгдсэн журмаар хамрагдана.
	2 дахь өдөр: Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> <li>Өмнөх төслийн үед боловсруулсан зөвлөмжийг танилцуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Энэхүү сургалтаар олж мэдсэнээ тус тусын сургуульд хэрхэн түгээвэл зохих вэ.</li> <li>БСГ, сургууль дээр хичээлийн судалгааг хэрэгжүүлэх, хэвшүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах</li> <li>Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин ба менежмент</li> </ul>
	Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн бэлтгэл судалгаа болон анхаарах зүйл</li> <li>Сурагчдын хандлага, түүнийг тооцох</li> <li>Хичээлийн судалгаанд оролцогчдын (Хичээл заах багш, ажиглагч, хэлэлцүүлгийн хөтөлгөч) үүрэг</li> </ul>	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
	3 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> <li>Туршилт хичээлд бэлтгэх</li> </ul>	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
	4 дэх өдөр: Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> <li>Туршилт хичээл явуулах, ажиглалт хийх</li> <li>Хэлэлцүүлэг зохион байгуулах</li> </ul>	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн хөтөлбөрөө сайжруулах</li> </ul>	БСГ, сургуулийн төлөвлөгөөнд хичээлийн судалгааны төлөвлөгөөгөө тусгах	
5 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> <li>БСГ, сургууль тус бүрээр хичээлийн судалгааг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах</li> <li>Бүх байгууллагуудын танилцуулга, зорилго, зорилт, төлөвлөгөөнийхөө тухай илтгэл тавих</li> </ul>	Бүх оролцогчид нэгдсэн журмаар лекцэд хамрагдана.	

Иший Тэцүя	Менежмент / Сургалтын төлөвлөгөө 1
Сүзүки Саяака	Сургалтын төлөвлөгөө 2/Мониторинг, үнэлгээ
Камата Масахино	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (байгалийн ухаан)
Такахата Хироши	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (бага дунд ангийн математик)
Фүкүчи Акихарү	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (байгалийн ухаан, төсөлт ажил)
Мацүүра Шюү	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (мэдээлэл зүй)
Б.Хишигбаяр	Сургалт зохион байгуулах/Хичээлийн судалгаанд дэмжлэг үзүүлэх

**Мэдлэг, ур чадвараа амьдралд бодитоор ашиглах чадвар: “Суралцах чадварын үнэлгээ”-ний дүн**

2009 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) 65 улс орон, бүс нутгийн 15 настай 470 мянга гаруй сурагчийг хамарсан “Суралцах чадварын үнэлгээ (PISA: OECD Programme for International Student Assessment)”-г зохион байгуулсан ба 2010 оны 12 дугаар сарын 7-нд энэ судалгааны дүнг зарлажээ. Суралцах чадварын үнэлгээ судалгаа нь 3 жил тутам хэрэгждэг бөгөөд 15 настай сурагчдын бага, дунд боловсролоор олж авсан мэдлэг, ур чадвараа амьдралд бодитоор ашиглах чадварыг нь тогтоох зорилгоор хэрэгждэг судалгаа юм. Япончууд “Уншиж ойлгох чадвар”-аар 8-р байр, “Математикийн үүднээс хандах чадвар”-аар 9-р байр, “Шинжлэх ухааны үүднээс хандах чадвар”-аар 5-р байрт шалгарчээ. Эдгээр гурван үзүүлэлтээр Азийн орнуудын сурагчид эхний 10 байрын талаас илүү хувийг эзэлсэн байна.

Суралцах чадварын үнэлгээний шалгуур болох мэдлэг ашиглах чадварт онцгой анхаарах нь дэлхий нийтийн хандлага болж байна. Монголын бага дунд боловсролд хүүхдүүдийн мэдлэг, ур чадвараа ашиглах чадварыг нь хөгжүүлдэг үү? Монголд 15 настай хүүхдийн “Уншиж ойлгох чадвар”, “Математикийн үүднээс хандах чадвар”, “Шинжлэх ухааны үүднээс хариулах чадвар”-ыг хангалттай хөгжүүлж байгаа юу?

Суралцах чадварын үнэлгээний тухай дэлгэрэнгүйг дараахи цахим хуудсаас үзнэ үү.  
<http://www.oecd.org/dataoecd/51/27/37474503.pdf>